

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2017 оны 44 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

**“ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ”
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР
/2017-2020 он/**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Гэр бүлийн хөгжил хамгааллын хэрэгцээ шаардлага өнөөгийн байдал

“Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал”¹ судалгаанаас үзвэл хотод төвлөрөл нэмэгдэх, хөдөөд хүн ам сийрэгших, ураг төрлийн харилцаа хөндийрөх, цус ойртолт бий болох, гэр бүлийн гишүүдийн үүрэг, эрх мэдлийн хуваарилалт өөрчлөгдөх, хожуу гэрлэлт нэмэгдэх, эрт бэлгийн харилцаанд орох, гэр бүл салалт (1989 оноос хойш тогтмол өсөж байна), хараа хяналтгүй хүүхэд нэмэгдэх, шүүхээр шийдвэрлэсэн гэр бүлийн эрх зүйн маргаан өсч, гэр бүлийн өмнө хуулиар хүлээсэн үүрэгт тавих хяналт суларч, гэр бүлийн хүчирхийлэл ихсэж байгаа нь харагдаж байна.

2014-2016 онд Ховд аймагт 111 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж 250 гаруй хүүхэд төрсөн эцэг, эхийн хайр халамжаас хөндийрч, хойд эцэг эх, хамтран амьдрагчийн хараа хяналтанд өсч байна. Энэ нь жилд 35-40 гэр бүл, сард 2-3 хосууд гэр бүлээ цуцлуулж байгааг харуулж байна.

Гэр бүл салалтын шалтгааны 54.0 хувь нь итгэл алдарсан, 47.3 хувь нь санхүүгийн бэрхшээлтэй, 41.3 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн хүчирхийлэлтэй холбоотой гомдол 144 бүртгэгдсэнээс хохирогчийн тоонд хүүхдүүдийг хохирогч хэмээн үзэхгүйгээс хүчирхийлэлтэй гэр бүлд өссөн хүүхэд төлөвшлөө олж чадахгүй, өөртөө итгэх итгэлгүй, цаашид дарангуйлагч, хүчирхийлэгч болдог сөрөг нөлөөтэй нь судалгаагаар нотлогдсон байна.

Насанд хүрээгүй хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэх гомдол, мэдээлэл аймгийн Цагдаагийн газарт 2012-2016 онд 42 бүртгэгдсэн ч эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээд байхгүй байгаа нь өсвөр насны охидыг зэрэмдэглэн насан туршид нь сэтгэлийн арилшгүй шарх үлдээсэн гэмт хэрэгтэн ял завшиж буйг нотолж байна. Энэ төрлийн хүчирхийлэл ихэнхдээ гэр бүл, ураг төрлийн хүрээнд үйлдэгдэж байгаа тул эцэг эх, асран хамгаалагчдын хараа хяналт, асрамж

халамжийг сайжруулах, урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч нөхөн сэргээх, гэр бүлд нь эргэн нэгтгэх, салбар байгууллагууд хамтын ажиллагааг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна³.

Сүүлийн 10 жилийн үзүүлэлтээс харахад Бэлгийн замын дамжих халдвар нэмэгдэж байгаа бөгөөд 2016 оны байдлаар аймагт тэмбүүгийн өвчлөл 10 000 хүн амд 11,6 хувьтай байна.

Төрөх эмэгтэйчүүдийн нас залуужиж 10 орчим хувийг 15-19 насны охид эзэлж, өсвөр насны охидын дунд бэлгийн хүчирхийллээс үүдэлтэй төрөлт өсөх хандлагатай байна.

Хүүхдийн бичил тэжээлийн дутагдал баруун бүсдээ хамгийн өндөр буюу 45.03, өсөлт хоцролттой хүүхдийн эзлэх хувь 30 байна.

Амьдрах орчин нөхцөл муу зэргээс өвчинд нэрвэгдэх, эмчилгээний зардлыг төлж чадахгүй, эцэг, эхийн хараа хяналт сул, мэдлэг, мэдээлэл дутмаг, эрт эмнэлэгт хандаагүй, ахуйн осол зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж эндэх тохиолдол их байна.

Иймээс гэр бүлд чиглэсэн хөгжил, хамгааллын хөтөлбөрийг орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлснээр хүний амьдралын анхдагч орчин болох гэр бүлийн гишүүдийн хандлага өөрчлөгдөж, тогтвортой, эерэг харилцаатай гэр бүл төлөвшиж, хүүхдэд ээлтэй орчин бүрдэнэ.

Хоёр. Хөтөлбөрийн уялдаа, холбоо

Энэхүү хөтөлбөр нь “Гэр бүлийн тухай”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Хүүхэд харах үйлчилгээний тухай” хуулиуд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас дэвшүүлсэн салбарын зорилго, зорилт, Ховд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, холбогдох Үндэсний хөтөлбөрүүдтэй уялдан хэрэгжинэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, гэр бүлийн хөгжил, боловсрол, тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх замаар гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилт, үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

4.1. Хамрах хүрээ: Ховд аймгийн 17 сум 91 багийн 21072 өрхийн 85325 хүн

амын 50%, 0-18 насны 32668 хүүхдийн 60%-ийг хамруулна.

4.2. Зорилт

Зорилт 1. Гэр бүлийн эрх зүйн орчны хэрэгжилтийг эрчимжүүлж, нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар тогтвортой байдлыг хангах, гэр бүлд ээлтэй нийгмийн орчинг бүрдүүлэх

Зорилт 2. Эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж гэр бүл дэх хүүхдийн хөгжил, хамгааллыг бэхжүүлнэ.

Зорилт 3. Алслагдсан бүс нутаг, зорилтот өрхөд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

Зорилт 4. Угийн бичиг хөтлөх үйл ажиллагааг эрчимжүүлж, цус ойртолтоос сэргийлэх, Монгол хүний удмын санг хамгаалах санаачлагыг дэмжих

Тав. Дэд хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ

	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага		Шаардагдах төсөв /мянган төгрөг/	
			Хариуцагч	Хамтрагч	Зардлын дүн	Эх үүсвэр
Зорилт-1. Гэр бүлийн эрх зүйн орчны хэрэгжилтийг эрчимжүүлж гэр бүлийн нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүчирхийллийг бууруулах						
1.1	Гэр бүлийн харилцааг зохицуулж буй хууль, тогтоомжийн хэрэгжилт, сургалт нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулах	2017-2020	ЗДТГ-ын НБХ, ХЭЗХ ГБХЗХГ	Цагдаагийн газар	6000.0	ОНХС
1.2	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг тохижуулж үйл ажиллагааг тогтмолжуулан, сэтгэл зүйч ажиллуулна	2018-2020	ЗДТГ-ын НБХ, ГБХЗХГ	Цагдаа, Эрүүл мэндийн газар	26000.0	ОНХС, бусад эх үүсвэр
1.3	Хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх, архи, тамхи, мансуурах төрлийн хэрэглээтэй иргэдийг хорт зуршлаас гаргах нөлөөллийн сургалт, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх	2017-2020	ЦГ ГБХЗХГ	ЗДТГ-ын НБХ, ХЭЗХ	4000,0	Дэлхийн зөн Ховд ОНХХ
Зорилт 2. Эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж гэр бүл дэх хүүхдийн хөгжил, хамгааллыг бэхжүүлнэ.						
2.1	Аймгийн Шилдэг гэр бүлийг шалгаруулах, урамшуулах	2017-2020	ЗДТГ-ын НБХ ГБХЗХГ	Сумдын ЗДТГ	8000,0	ОНХС

2.2	Хүн амын бүлгийг хамарсан чуулган зохион байгуулах /эцэг эхийн, эмэгтэйчүүдийн, гэр бүлийн гэх мэт/	2017-2020	ЗДТГ-ын НБХ ГБХЗХГ	Сумдын ЗДТГ	10000,0	ОНХС
2.3	Өсвөр үе, залуучуудад гэр бүл төлөвлөлт, амьдрах ухаан, нөхөн үржихүйн боловсрол, гэр бүл төлөвлөлтийн талаарх сургалт, сурталчилгаа зохион байгуулах	2017-2020	ГБХЗХГ ЭМГ БСУГ	ХХҮГ Залуучуудын хөгжлийн төв	6000,0	ДЗХОНХХ Залуучуудын хөгжлийн төв
2.4	Гэр бүлийн гишүүдийн бие биедээ тавих анхаарал халамж, хүүхэддээ зарцуулах цагийг бий болгох "Гэр бүлийн өдөр" арга хэмжээг зохион байгуулах	2017-2020	ЗДТГ-ын НБХ ГБХЗХГ	БСУГ,ЦГ, ХХҮГ,ЭМГ, БТСГ, Жаргалант сум	4000,0	ДЗХОНХХ
2.5	Амьдарлын зөв хэвшил, амьдрах арга ухааныг сурталчилсан "Гэр бүлийн цаг" телевизийн цуврал нэвтрүүлэг тогтмол бэлтгэн олон нийтэд хүргэх	2017-2020	ЗДТГ-ын НБХ ГБХЗХГ	Орон нутгийн ТВ	7000,0	ОНХС
2.6	Гэр бүлийн гишүүдийг оролцуулсан уралдаан тэмцээн, нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулах	2017-2020	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ	8000,0	ОНХС
Зорилт 3. Алслагдсан бүс нутаг, зорилтот өрхөд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.						
3.1	Алсагдсан бүс нутагт ажиллаж амьдарч буй гэр бүлд гэр бүлийн болон амьдрах ухаан, нөхөн үржихүйн боловсрол олгох арга замыг бий болгох сэтгэл зүй, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх	2017-2020	БСУГ ЭМГ ГБХЗХГ	Сумдын ЗДТГ	4000,0	ОНХС
3.2	Хилчдийн боловсролыг суралцахад үзүүлэх бүрдүүлэх хилийн заставуудад хүүхэд харах үйлчилгээг эргөжүүлэх, ажлын байр бий болгох хүүхдийн дэмжих, дэмжлэг боломжийг хилийн хүүхэд харах өргөжүүлэх,	2017-2020	ГБХЗХГ Үенч сумын ЗДТГ	Хилийн цэргийн 0130 дугаар анги	183600,0	Улсын төсвөөс

3.3	Зорилтот өрх /эрсдэлт нөхцөл дэх гэр бүл, хүүхэд, өрх толгойлсон эх, эцэг/-ийн нөхцөл байдлыг үнэлж, нөхөн сэргээх, холбон зуучлах ажил үйчилгээг тогтмол зохион байгуулах	2017-2020	ГБХЗХГ Сумдын ЗДТГ	ЭМГ ЦГ ХХҮГ БСУГ	20000,0	Хүүхэд хамгааллын зардал
4. Угийн бичиг хөтлөх үйл ажиллагааг эрчимжүүлж цус ойртолтоос сэргийлэх, Монгол хүний удмын санг хамгаалах санаачлагыг дэмжих						
4.1	Аймаг, сумдад ажлын хэсэг байгуулж, нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2017-2020	ЗДТГ-ын НБХ ГБХЗХГ БСУГ	Сумдын ЗДТГ	-	-
4.2	Цус ойртолтоос сэргийлж Монгол хүний удмын санг хамгаалах гэр бүлийн тогтвортой байдлыг хангах боловсрол олгох явуулын бүсчилсэн сургалт зохион байгуулах	2017-2020	БСУГ Нийтийн номын сан	Сумдын Соёлын төв	3000,0	ОНХС
4.3	Өрх бүр угийн бичиг хөтлөх, ургийн баяр хийх, ёс заншил, амьдрал ахуй, соёлыг хадгалж, удмын санг хамгаалах үйл ажиллагааг дэлгэрүүлэх	2018-2020	ЗДТГ-ын НБХ ГБХЗХГ БСУГ	Сумдын ЗДТГ	8000,0	ОНХС
НИЙТ ДҮН		Орон нутгийн хөгжлийн сангаас			80 000.0	
		Олон улсын төсөл, хөтөлбөр болон бусад сангийн дэмжлэгээр			14000.0	
		Төсөв тодорхойгүй			-	
		Улсын төсвөөс			183600.0	

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа, санхүүжилт, тайлагналт, шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа

- Хөтөлбөрийг 2017-2020 оныг дуустал хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр

6.2.1. Засаг даргын нөөц хөрөнгө

6.2.2. Орон нутгийн хөгжлийн сан

6.2.3. Олон улсын болон төрийн бус байгууллагын тусламж, дэмжлэг

6.2.4. Улсын төсөв

6.3. Хөтөлбөрийн тайлагналт

1/ Дэд хөтөлбөрийн биелэлтийн тайланг бүтэн жилээр гаргаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлнэ.

Д. д	Үзүүлэлт	2016 оны түвшин	2020 онд хүрэх түвшин
1.	Гэр бүлийн боловсрол олгох бодлого, стратегитэй уялдуулан зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлгийн тоо	12	36
2.	Гэр бүлийн харилцаа, хүмүүжил төлөвшлийн сургалтанд сууж мэдээлэл авсан иргэдийн тоо	30%	50%
3.	Гэр бүл, хүүхдэд ээлтэй бодлогыг хэрэгжүүлсэн байгууллагын тоо	54	150
4.	Албан байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд “Гэр бүл”-ийн зөвлөл байгуулж ажилтнуудынхаа гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжиж бүтээлчээр туслах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байгууллагын тоо	54	150
5.	Гэр бүлийн үнэ цэнэ, сайн сайхан байдлыг сурталчлах, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр хийгдсэн телевизийн нэвтрүүлгийн тоо	10	24
6.	Гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, чуулган, уулзалтанд хамрагдсан хүмүүсийн тоо	6000	18000
7.	Гэр бүлд зөвлөгөө өгөх төв тохижуулахад шаардагдах тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд зарцуулах хөрөнгийн хэмжээ \мянган төгрөгөөр\	2000.0	8000.0
8.	Гэр бүлийн хүчирхийллийн өсөлт, бууралтын байдал \Хувиар\	165 иргэн өртсөн.	50 хувиар бууруулна
9.	Гэр бүлийн асуудлаарх зөвлөгөө, сургалт, мэдээллийн хүртээмжийн өсөлт, бууралт	182	50 хувиар өсгөнө
10.	Гэр бүл цуцлалтын тоо	111	20 хувиар бууруулна.
11.	Хөтөлбөрийн хүрээнд өөрчлөлт орсон, шинээр боловсруулсан гэр бүлд ээлтэй бодлого, дүрэм, журам, шийдвэрүүдийн тоо	4	18
12.	Төрийн болон төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудын тоо	6	50% өсгөнө
13.	Гэр бүлийн зөвлөгөө авсан хүмүүсийн тоо	200	500

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

14.	Цус ойртолтоос сэргийлж Монгол хүний удмын санг хамгаалах гэр бүлийн тогтвортой байдлыг хангах боловсрол олгох явуулын бүсчилсэн сургалт, судалгаа мэдээллийн сан бүрдүүлэх	-	Мэдээлийн сан бүрдэнэ
15.	Угийн бичиг хөтлөсөн өрхийн тоо, ургийн баярын тоо	-	Нийт өрхийн 40 % хамруулна
16.	Гэр бүлийн гишүүдийг оролцуулсан уралдаан тэмцээн, наадам нөлөөллийн ажлын тоо	3	12
17.	Гэр бүлийн чуулган зөвлөгөөний тоо	0	1
18.	Хилийн заставуудад ажиллаж байгаа хүүхэд харах үйлчилгээний тоо	8	8
19.	Зорилтот өрхийн тоо	654	20 хувиар бууруулна

---oOo---